



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/18/-НА-СТА-ТТЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ 5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө	10
3.5.2 Авлага	11
3.5.4 Бараа материал	11
3.5.6 Үндсэн хөрөнгө	12
3.5.7 Өр төлбөр	12
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.3 Зөвлөмж	19
7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.03.25 № 4/238
танай _____-ны № _____-г

ТӨВ АЙМГИЙН БАЯНЦОГТ СУМЫН
ЗАСАГ ДАРГА А.ДАВААДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Баянцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 33 зорилт 181 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 95.09%-тай буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг дарга тайлант онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 220,309.3 мянган төгрөгөөр Зараагийн дэнжийн цахилгааны өргөтгөл, Үйлдвэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах, 12 айлын орон сууцны дээвэр, гадна фасадын засварын ажлыг хийж гүйцэтгүүлсэн ба Эрүүл мэндийн төвд физик эмчилгээний төхөөрөмжийг худалдан авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		584,996.2	622,184.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	385,991.1	235,313.1
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	145,587.5	315,068.2
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	52,592.7	60,603.3
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	825.0	11,200.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,646,935.4	1,801,751.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,646,935.4	1,801,751.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		2,231,931.6	2,423,936.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		2,231,931.6	2,423,936.1
51	Засгийн газрын хувь оролцоо		2,231,931.6	2,423,936.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		2,231,931.6	2,423,936.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,467,429.80	1,953,858.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	240,530.30	321,893.70
110	Орлогын албан татвар	136,718.60	203,845.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	153,540.60	221,845.50
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-16,822.00	-18,000.00
113	Хөрөнгийн албан татвар	51,418.70	69,936.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	52,393.00	48,111.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	593,067.50	611,909.10
120	Нийтлэг татварын бус орлого	593,067.50	598,409.10
122	Тусламжийн орлого	0	13,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,633,831.90	1,020,055.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,163,337.60	1,761,854.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,962,666.60	1,499,453.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,061,643.20	1,481,447.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	279,552.50	432,857.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,075.20	54,798.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	311,769.90	74,757.70
2104	Хангамж, бараа материалын зардал	35,694.40	22,837.90
2105	Нормативт зардал	92,915.40	89,859.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,350.00	8,111.70
2107	Томилолт, зочны зардал	4,524.00	4,347.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,178.10	2,615.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	295,583.80	791,262.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	901,023.30	18,005.70
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	200,671.00	262,400.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	304,092.20	192,004.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,404,920.60	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,100,828.40	192,004.50

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,143,826.80	1,500,769.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	240,530.30	321,893.70
110	Орлогын албан татвар	136,718.60	203,845.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	153,540.60	221,845.50

1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-16,822.00	-18,000.00
113	Хөрөнгийн албан татвар	51,418.70	69,936.30
118	Бусад татвар, төлбөр, хураамж	52,393.00	48,111.90
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,005.90	4,065.50
1181	Газрын төлбөр	45,353.60	41,520.60
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,033.50	2,525.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	269,464.60	158,820.10
120	Нийтлэг татварын бус орлого	269,464.60	145,320.10
122	Тусламжийн орлого	0	13,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,633,831.90	1,020,055.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,710,961.40	1,079,274.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,710,961.40	1,079,274.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	786,078.00	1,061,268.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	277,015.90	431,166.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,830.20	54,402.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	312,121.00	74,237.70
2104	Хангамж, бараа материалын зардал	17,948.90	18,883.30
2105	Нормативт зардал	0	999.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,350.00	7,147.70
2107	Томилолт, зочны зардал	4,360.00	4,143.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,202.50	3,253.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	133,249.50	467,035.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	924,883.40	18,005.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	432,865.40	421,495.10
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0	0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	321,879.90	388,008.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	321,879.90	388,008.20
2200	Дотоод эх үүсвэрээр	321,879.90	388,008.20
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-321,879.90	-388,008.20
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-504.6	-184,164.80
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	504.6	184,164.80
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	110,481.00	-150,678.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	275,510.10	385,991.10
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	385,991.10	235,313.10

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,417,078.20	4,417,078.20
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-84,318.20	-84,318.20
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,332,760.00	4,332,760.00
9	Тайлант үеийн үр дүн	-2,100,828.40	-2,100,828.40
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,231,931.60	2,231,931.60
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,231,931.60	2,231,931.60
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,231,931.60	2,231,931.60
19	Тайлант үеийн үр дүн	192,004.50	192,004.50
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	2,423,936.10	2,423,936.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,542,241.80	1,438,962.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	962,144.50	932,655.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	961,044.50	931,655.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,301.10	409,031.30
210101	Үндсэн цалин	342,104.00	296,988.16

210102	Нэмэгдэл	75,824.80	102,348.56
210104	Урамшуулал	52,795.60	51,641.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,173.00	4,131.35
210201	Тэтгэврийн даатгал	3,338.30	3,305.02
210202	Тэтгэмжийн даатгал	834.50	826.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,346.10	8,262.70
210204	Ажилгүйдлийн даатгал	418,896.80	408,900.96
210205	Эрүүл мэндийн даатгал	40,758.70	31,487.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	376,308.10	376,258.25
210301	Гэрэл, цахилгаан	1,830.00	1,155.00
210302	Түлш, халаалт	18,800.30	16,885.33
210303	Цэвэр, бохир ус	2,247.90	2,230.40
2104	Хангамж, бараа материалын зардал	2,866.00	1,686.30
210401	Бичиг хэрэг	2,500.00	1,803.30
210402	Тээвэр, шатахуун	1,000.00	999.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,000.00	999.50
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,297.70	12,287.70
2105	Нормативт зардал	5,099.20	4,143.20
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	540.00	540.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	230.00	152.18
210604	Урсгал засвар	20,298.80	19,235.19
2107	Томилолт, зочны зардал	3,620.00	3,568.14
210702	Дотоод албан томилолт	1,100.00	1,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	372,237.30	322,142.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	257,863.60	236,840.54
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	59,337.70	37,057.20
210803	Даатгалын үйлчилгээ	55,036.00	48,244.88
210804	Тээврийн хэрэгслийн татвар	207,860.00	184,164.85
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	207,860.00	184,164.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,002,144.50	1,013,906.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	291,032.80	30,160.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	207,860.00	30,160.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,100.00	1,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	257,863.60	236,840.54
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,002,144.50	1,013,906.54
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,002,144.50	1,013,906.54
221001	Их засвар	207,860.00	30,160.91
222001	Тоног төхөөрөмж	83,172.80	0.00
223001	Бусад хөрөнгө	20,000.00	13,500.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	226,818.56
230001	Эргэж төлөгдөх зээл	0.00	68,753.18
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,542,241.80	1,280,897.56
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	229,064.50	223,330.10
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	291,032.80	30,160.91
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	207,860.00	30,160.91
320001	Орон нутгийн төсвөөс	83,172.80	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	291,032.80	30,160.91
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	207,860.00	30,160.91
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	20,000.00	13500
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	0.00	226,818.56
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	0.00	68,753.18
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	226,818.56
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	68,753.18
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	54	54
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
610001	Төсвийн байгууллага	2	2
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26	26
620001	Удирдах ажилтан	8	8
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	5	5
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	26	26
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11	11
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9	9
650010	Гэрээт ажилтан	1	1
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	111,315.2	133,886.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,315.2	77,770.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36,524.5	40,773.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	0.0	22,134.7
210101	Үндсэн цалин	0.0	5,059.3
210102	Нэмэгдэл	0.0	17,075.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	2,760.4
210201	Тэтгэврийн даатгал	0.0	2,104.1
210202	Тэтгэмжийн даатгал	0.0	184.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.0	177.5
210204	Ажилгүйдлийн даатгал	0.0	38.8
210205	Эрүүл мэндийн даатгал	0.0	255.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	736.1	0.0
210302	Түлш, халаалт	736.1	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,368.3	1,998.0
210401	Бичиг хэрэг	134.0	0.0
210402	Тээвэр, шатахуун	1,234.3	1,998.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300.0	41.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300.0	41.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,120.2	13,839.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,120.2	13,139.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.0	700.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,790.7	36,996.9
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	14,790.7	36,996.9
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	14,790.7	0.0
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	36,996.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	60,000.0	56,115.6
2200	Дотоод эх үүсвэрээр	60,000.0	56,115.6
222001	Тоног төхөөрөмж	60,000.0	0.0
223001	Бусад хөрөнгө	0.0	56,115.6
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	111,315.2	133,886.4
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	111,315.2	133,886.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	111,315.2	98,769.7
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	35,116.8

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянцогт сумын Засаг дарга нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, түүнчлэн тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн” гэж заасан ба мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Сумын Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 59.1.1-59.1.23-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлдэг байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 14.2.1-14.2.12-т заасан бүрэн эрхийг, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасан бүрэн эрхийг тус тус хэрэгжүүлэн, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаа аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчид нэгтгэн тайлагнадаг байна.

Төв аймгийн Баянцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 18-ны 01 дүгээр тогтоолоор сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн 33 зорилт 181 арга хэмжээний хэрэгжилтийн явцыг 95.09%-тай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянцогт сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Шилэн дансны тухай хууль зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамрагдаагүй, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын дотоод хяналтын баг нь төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд 2023 онд 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Баталсан удирдамж төлөвлөгөөний төсөвт байгууллагуудын шилэн данс, өмч ашиглалт, хөрөнгө оруулалтын ажлын явц, тусгай сангуудын үйл ажиллагаа, газар олголт, татварын орлогын төлөвлөгөөний хэрэгжилтэд удирдамжийн дагуу хяналт шалгалтыг хийж, ажлын дүгнэлт тайланг бичсэн байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын нэгтгэсэн тайланд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Аймгийн засаг даргын захирамжаар 2021 оны 03 сард баталсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,423,936.10 мянган төгрөг болж, өмнөх оноос 192,004.5 мянган төгрөгөөр буюу 8,6 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	385,991.1	235,313.1
33	АВЛАГА	145,587.5	315,068.2
35	БАРАА МАТЕРИАЛ	52,592.7	60,603.3
36	НӨӨЦИЙН БАРАА	825.0	11,200.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,646,935.4	1,801,751.5
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,231,931.6	2,423,936.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	583,742.8	583,742.8
51200	Хуримтлагдсан үр дүн	1,328,611.8	1,520,616.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	319,577.0	319,577.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,231,931.6	2,423,936.1

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 235,313.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 150,678.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Хоршоо хөгжүүлэх сангийн мөнгөн хөрөнгө 31,186.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 154,003.9 мянган төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 315,068.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 169,480.7 мянган төгрөгөөр өссөн нь Орон нутгийн хөгжлийн сангийн авлага 10,000.0 мянган төгрөг болж нэмэгдсэн, Хоршоо хөгжүүлэх сангийн авлага 303,392.9 мянган төгрөг болж 159,552.3 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Бараа материалын эцсийн үлдэгдэл 60,603.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,010.6 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын бараа материал 38,404.9 мянган төгрөг болж 6,875.6 мянган төгрөгөөр өссөн, эмийн эргэлтийн сангийн бараа материал 20,671.9 мянган төгрөг болж 1,202.0 мянган төгрөгөөр өссөн нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,801,751.5 мянган төгрөг болж, өмнөх оноос - 154,816.1 мянган төгрөгөөр өссөн нь ЗДТГ-ын үндсэн хөрөнгө 1,794,285.4 мянган төгрөг болж 150,082.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн, Эмийн эргэлтийн сангийн үндсэн хөрөнгө 3,875.0 төгрөг болж өссөн нөлөөлсөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 705,939.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 452,034.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	385,991.1	235,313.1	-150,678.0
Төгрөг	385,991.1	235,313.1	-150,678.0
Төрийн сангийн харилцах	309,535.2	151,703.1	-157,832.1
Арилжааны банк дахь харилцах	76,455.9	83,610.0	7,154.1
Дүн	1,157,973.3	705,939.3	-452,034.0

Эх сурвалж: Баянцогт Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн Төрийн сангийн харилцах дансны эцсийн үлдэгдэл 151,703.1 мянган төгрөгийн 49,3 хувь буюу 74,787.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвийн орлогын, 24,8 хувь буюу 37,566.3 мянган төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн, 20,6 хувь буюу 31,186.8 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн, 5,4 хувь буюу 8,162.1 мянган төгрөгийг Байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа сангийн дансны үлдэгдэл эзэлж байна. Эмийн эргэлтийн сангийн үлдэгдэл арилжааны банканд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 150,678.0 мянган төгрөгөөр буурсан нь Хоршоо хөгжүүлэх сангийн 182,000.0 мянган төгрөгийн зээл олголттой холбоотой байна.

Аудитын илрүүлэлт

1. Баянцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны “ИТХ-ын даргын цалингийн хэмжээ нэмэгдлийг тогтоох тухай” 03 тогтоолоор төрийн албаны улс төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 2,525.3 мянган төгрөг олгосон зөрчилд төлбөрийн акт бичив.

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 315,068.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 169,480.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
АВЛАГА ДҮН	145,587.5	315,068.2	169,480.7
Бусад авлага	145,587.5	315,068.2	169,480.7
Байгууллагаас авах авлага	1,746.8	11,055.3	9,308.5
Хувь хүмүүсээс авах авлага	143,840.7	304,012.9	160,172.3

Эх сурвалж: Баянцогт Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын жилийн эцсийн үлдэгдэл 315,068.2 мянган төгрөгийн 94,5 хувийг буюу 304,012.9 мянган төгрөгийг хүмүүсээс авах авлага эзэлж байна. Хувь хүмүүсээс авах авлагын 99,8 хувь буюу 303,392.9 мянган төгрөг нь хоршоо хөгжүүлэх сангийн авлага байна.

Аудитын илрүүлэлт

Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга тайланд Хоршоо хөгжүүлэх сангийн 304,012.9 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлээгүй гэж тайлагнасныг аудитын явцад залруулсан.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 71,803.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 18,385.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	4,799.9	19,811.1	15,011.2
Эм боох материал	19,176.2	20,378.2	1,202.0
Бичиг хэргийн материал	989.7	587.7	-402.0
Аж ахуйн материал	12,236.9	13,856.4	1,619.5
Сэлбэг хэрэгсэл	120.0	620.0	500.0
Бусад хангамжийн материал	10,270.0	350.0	-9,920.0
Мал амьтад	5,000.0	5,000.0	0.0
Нөөцийн бараа	825.0	11,200.0	10,375.0
Дүн	53,417.7	71,803.3	18,385.7

Эх сурвалж: Баянцогт Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын эцсийн үлдэгдэл 71,803.3 мянган төгрөгийн 69,1 хувийг ЗДТГ, 28,8 хувийг эмийн эргэлтийн сан, 2,1 хувийг ИТХ-ын бараа материал эзэлж байна.

Бараа материалын оны эхний үлдэгдэл 18,385.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 15,009.7 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 2,466,663.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 306,542.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	1,336,541.9	1,400,535.1	63,993.2
Тээврийн хэсэгсэл	216,959.1	216,959.1	0.0
Машин тоног төхөөрөмж	241,098.1	260,023.8	18,925.7
Тавилга эд хогшил	144,342.5	165,584.5	21,242.0
Зам гүүрийн байгууламж	145,535.7	145,535.7	0.0
Номын фонд	1,233.5	1,233.5	0.0
Бусад үндсэн хөрөнгө	31,400.0	230,281.7	198,881.7
Програм хангамж	1,950.3	5,450.3	3,500.0
Бусад биет бус хөрөнгө	41,060.0	41,060.0	0.0
Дүн	2,160,121.0	2,466,663.6	306,542.6

Эх сурвалж: Баянцогт Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн 2,466,663.6 мянган төгрөгийн үлдэгдлийн 99,4 хувь буюу 2,451,628.3 мянган төгрөгийг сумын ЗДТГ, 0,23 хувь буюу 5,624.8 мянган төгрөгийг ИТХ, 0,03 хувь буюу 800.0 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сан, 0,35 хувь буюу 8,610.5 мянган төгрөгийг эмийн эргэлтийн сангийн хөрөнгө эзэлж байна.

Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 306,542.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 247,657.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 58,885.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсантай холбоотой байна.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр байхгүй

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 2,423,936.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 192,004.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	583,742.8	583,742.8	0.0
Дахин үнэлгээний нөөц	319,577.0	319,577.0	0.0
Хуримтлагдсан дүн	1,328,611.8	1,520,616.4	192,004.6
Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	2,231,931.6	2,423,936.2	192,004.6

Эх сурвалж: Баянцогт Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл өмнөх оноос 192,004.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Баянцогт сумын ИТХ-ын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Сумын 2023 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолоор 2023 онд төсөвт төвлөрүүлэх татварын ба татварын бус орлогыг 294,606.2 мянган төгрөгөөр, төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг 1,251,441.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төслийн саналаас Баянцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 01 дугаар тогтоолд зааснаар Баянцогт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 329,631.4 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр тодотгон баталж гүйцэтгэлээр 331,059.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100,4 хувиар биелүүлсэн байна. Татварын 6 нэр төрлийн орлого тасарсан байна.

Тайлант онд орон нутагт төвлөрүүлэх орлогоос 3,084.0 мянган төгрөгөөр үйл ажиллагааны орлого, 976.0 мянган төгрөгөөр суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар, 21,295.7 мянган төгрөгөөр газрын төлбөр, 4,884.1 мянган төгрөгөөр ойн төлбөр, 29,678.5 мянган төгрөгөөр газрын дуудлага худалдааны орлого, 3,103.5 мянган төгрөгөөр хүү торгуулийн орлого, нийт 63,021.8 мянган төгрөгөөр тасарсан байна. Ойгоос мод ашигласны төлбөр нь хур бороо ихтэй, цэвэрлэгээний ажлын хэрэглээний мод бэлтгээгүй, хүү торгуулийн орлого нь цагдаагийн хэсгийн бэлэн бус торгуулийн багаж ажиллахгүй байсан, газрын дуудлага худалдааны орлого нь дуудлага худалдаанд орж ялсан иргэн нь төлбөрөө төлөөгүй зэргээс шалтгаалан тус тус орлого тасарсан байна.

Төв аймгийн Баянцогт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 01 дугаар тогтоолоор Засаг даргын үйл ажиллагааны зардлыг 271,455.8 мянган төгрөгөөр бууруулан 544,866.9 мянган төгрөгөөр, ИТХ-ын үйл ажиллагааны зардлыг 2,841.0 мянган төгрөгөөр бууруулан 82,591.8 мянган төгрөгөөр, Хөрөнгийн зардлыг 357,237.3 мянган төгрөгөөр нэмж тодотгон, татварын орлогын төлөвлөгөөнд 35,025.5 мянган төгрөг, сумын төсөвт аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийн төлөвлөгөөнд 14,984.2 мянган төгрөг, орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн төлөвлөгөөнд 41,354.6 мянган төгрөгөөр өөрчлөлт оруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвийн орлогоос 329,631.4 мянган төгрөг, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 672,513.1 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 229,064.5 мянган төгрөг, төсвийн урьд оны шилжих үлдэгдлээс 20,000.0 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн шилжих үлдэгдэл 41,627.8 мянган төгрөг, малын тоо толгойн албан татварын шилжих үлдэгдлээс 6,509.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,544,184.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 103,222.1 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,440,962.8 мянган төгрөг буюу 93,3 хувьтай байгаа Хоршоо хөгжүүлэх сангийн зардлыг 23,695.1 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн зардлыг 47,800.8 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ. Төсвийн тодотголоор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулж

тендер зарласан бөгөөд гүйцэтгэгч нь шалгарч ажил нь хийгдээгүй нь нөлөөлсөн байна.

Хөрөнгө оруулалтын 6 хөтөлбөрийн 13 арга хэмжээнд 322,201.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 272,400.5 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Зарцуулах төсөв	Зарцуулсан	Зөрүү	Биелэлт
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	84,535.0	77,956.5	6,578.5	92.2%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	579,902.9	564,637.7	15,265.2	97.4%
3	70106-Хоршоо хөгжүүлэх сан	207,860.0	184,164.9	23,695.1	88.6%
4	71802-Ерөнхий боловсролын сургууль-Тогтмол зардал	222,414.6	218,667.0	3,747.6	98.3%
5	71801-Сургуулийн өмнөх боловсрол-Тогтмол зардал	26,593.3	24,946.9	1,646.4	93.8%
6	71702-Соёлын үйлчилгээ-Тогтмол зардал	35,648.3	31,791.4	3,856.9	89.2%
7	71602-Эрүүл мэндийн төв-Тогтмол зардал	65,029.5	64,397.9	631.6	99.0%
8	70106-Орон нутгийн хөгжлийн сан	322,201.3	274,400.5	47,800.8	85.2%
Дүн		1,544,184.9	1,440,962.8	103,222.1	93.3%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн харилцах дансаар сумын Засаг даргын тамгын газар нь 123,073.3 мянган төгрөг, ИТХ 10,813.1 мянган төгрөг, нийт 133,886.4 мянган төгрөгийг зарцуулсан байна

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 6 хөтөлбөрийн 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 11. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан	Хувь
1	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид, хороо ажлын хэсгүүдэд үзүүлэх үйлчилгээ	Сумын ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгчдийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажил үйлчилгээгээр хангаж, мэргэшсэн тогтвортой өндөр чадавх бүхий аппарат бүрдүүлж, ИТХ-ын	80,535.0	74,797.3	92.9%

				тэргүүлэгчдийн хуралдааныг зохион байгуулж жилд 7 удаа хуралдсан байна. Багийн ИНХ-ыг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллаж байна. ИТХ-ын хороодын хийх ажлыг төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг тооцон дүгнэлт өгсөн.			
2	70105- Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага	2023.01.01 2023.12.31	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны нэгдсэн хөтөлбөр дагуу явагдаж үр дүнг бодитой тооцно.	ГХУС дэд зөвлөлүүд ажлын төлөвлөгөө гарган ИТХ-ын хуралдаанд танилцуулан ажилласан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл шалгалтыг 45 удаа зохион байгуулж ажилласан бөгөөд 12-р сарын байдлаар малын хулгайн гэмт хэрэг 3, иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2, гэр бүлийн хүчирхийллийн эсрэг гэмт хэрэг 1, бусад 1 нийт 7 гэмт хэрэг бүртгэгдэж, үүнээс 50%-ийг илрүүлэн шийдвэрлэсэн байна.	4,000.0	3,159.2	79.0%
3	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Сумын хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлж ажиллана.	Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр биелэлт-95.09%-тай дүгнэгдэж сумын ИТХ-ын хуралдаанаар "Хангалттай" дүгнэгдсэн.	560,104.1	545,758.3	97.4%
4	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн нөөц хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээ	Онцгой байдлын хүрээнд /малын гоц халдварт цэцэг өвчин / гарсан Тээвэр шатахуун, хоол хүнс болон тэтгэмж урамшуулал шагналын зардалд шийдвэрлэсэн байна.	5,000.0	4,999.8	100.0%
5	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	Байгаль орчныг хамгаалах тээвэр шатахуун, нөхөн сэргээлт, ойжуулалт, хогийн савын хангалт зэрэг ажлууд бүрэн хийгдсэн.	8,798.8	7,879.6	89.6%
6	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Ажилчдын нийгмийн баталгааг хангаж тэтгэмж урамшуулал олгоно.	Төрийн дээд одон медаль авсан 2 албан хаагч, Ажилдаа идэвх санаачилгатай ажилласан 5 албан хаагчдад тэтгэмж урамшуулал олгосон.	1,000.0	1,000.0	100.0%
7	70106- Орон нутгийн	2023.01.01 2023.12.31	Улсын их баяр наадмын арга	Улсын баяр наадмыг товлосон хугацаанд	5,000.0	5,000.0	100.0%

	гүйцэтгэх засаглалын удирдлага		хэмжээг зохион байгуулна.	зохион байгуулан ажилласан.			
8	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01 2023.12.31	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт /ОНХС/	ОНХС-аар 12 ажил төлөвлөгдөж 11 ажил бүрэн хийгдэж 1 ажил цаг хугацаанаас болоод хэрэгжээгүй байна. Хийгдэх ажил 92.3% хэрэгжсэн. Тендерийн хэмнэлт үүссэн 17,293.5 мянган төгрөг байна.	322,201.3	274,400.5	85.2%
9	71802- Ерөнхий боловсролын сургууль	2023.01.01 2023.12.31	12 жилийн дунд сургуулийн тогтмол зардлыг санхүүжүүлнэ.	Тус байгууллагын халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг 100% санхүүжүүлж хэмнэлтийг төвлөрүүлж ажилласан.	222,414.6	218,667.0	98.3%
10	71801- Сургуулийн өмнөх боловсрол	2023.01.01 2023.12.31	Хүүхдийн цэцэрлэгийн тогтмол зардлыг санхүүжүүлнэ.	Тус байгууллагын халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг 100% санхүүжүүлж хэмнэлтийг төвлөрүүлж ажилласан.	26,593.3	24,946.9	93.8%
11	71602-Эрүүл мэндийн төв	2023.01.01 2023.12.31	ЭМТ-ийн тогтмол зардлыг санхүүжүүлнэ.	Тус байгууллагын халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг 100% санхүүжүүлж хэмнэлтийг төвлөрүүлж ажилласан.	65,029.5	64,397.9	99.0%
12	71702- Соёлын үйлчилгээ	2023.01.01 2023.12.31	Соёлын төвийн тогтмол зардлыг санхүүжүүлнэ.	Тус байгууллагын халаалт, гэрэл цахилгаан, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг 100% санхүүжүүлж хэмнэлтийг төвлөрүүлж ажилласан.	35,648.3	31,791.4	89.2%
13	70106- Хоршоо хөгжүүлэх сан	2023.01.01 2023.12.31	Хоршоо хөгжүүлэх сангийн журмыг дагаж мөрдөх. Хоршоо хөгжүүлэх сангаас иргэн, хоршоонд олгох зээлийг журмын дагуу шаардлага хангасан төсөл шалгаруулан зээл олгох, зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэх	2023 онд Хоршоо хөгжүүлэх сангаас нийт 5 иргэн, ААН-д 182,000.0 мянган төгрөгийн зээл олгосон байна. Бичиг хэрэг, Тээвэр шатахуун, Урамшуулал, программын төлбөрт нийт 2164.8 мянган төгрөг нийт 184164.9 мянган төгрөгийн гүйцэтгэл гарсан байна.	207,860.0	184,164.9	88.6%

Баянцогт сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 40 бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар 621,073.1 мянган төгрөгөөр баталсан ба 40 бараа, ажил үйлчилгээг 598,409.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

32 бараа, ажил үйлчилгээг 235,749.3 мянган төгрөгөөр Агтны манлай ХХК, Эс эм эн ай эс эм ХХК, Досей ХХК, Ник ХХК, Тэгш-Анар ХХК, Монгол шуудан ХК, Мегастори ХХК, Квант сервис ХХК, Хустайн шил ХХК, Эм би жи ХХК, ЭЧМ ХХК, Б.Ганбаатар, Ж.Ганзориг, Д.Пэрэнлэй, Ж.Нармандах, Р.Батболд, Н.Мөнхтөр, М.Гэрэлтод, М.Оюунбаатар, н.Цогточир, Л.Сайнбилэг, С.Намжилсүрэн нараас шууд худалдан авалт хийсэн байна.

Тайлант онд 152,855.6 мянган төгрөгийн тээвэр шатахуун, хоол хүнс, үдийн цайны материал нийлүүлэх 3 багц худалдан авалтыг тендер шалгаруулалтын онцгой журмаар зарласан бөгөөд Ник ХХК шалгаран гэрээ байгуулсан ба оролцогч ирээгүй багцууд дээр шууд худалдан авалт хийсэн байна.

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 220,309.3 мянган төгрөгөөр 5 төсөл арга хэмжээг тендер шалгаруулалтын онцгой журмаар худалдан авахаар төлөвлөсөн байна. Үйлдвэр хороололд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг Хаанбагана ХХК, Цахилгааны өргөтгөл хийх /Зараагийн дэнж/ ажлыг Ингүүмэл эрчим ХХК, 12 айлын орон сууцны дээвэр, гадна фасад засварын ажлыг Содон сод оюу ХХК, ЭМТ-ийн физик эмчилгээний тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг Ач есөн эх ХХК, Дунд-урт үйлчилгээний төвийн авто зогсоолын ажлыг ЗТЭЗ ХХК хийж гүйцэтгэхээр тус тус шалгаран, хийж гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын орлого бүрдүүлэлт, шилэн дансны мэдээллийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Адъяасүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт сумын Засаг даргын 2024 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн 01/54 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сумын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаас нийт орлого, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаас нийт орлого 1,582,489.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 23,737.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17,803.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баянцогт сумын Засаг дарга нь Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 178 мэдээлэл байршуулахаас 105 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 73 мэдээлэл хугацаа хоцроож, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 396,687.8 мянган төгрөгийн 28 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 95,910.7 мянган төгрөгийн 5 мэдээлэл, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэлтэй холбоотой 382,554.5 мянган төгрөгийн 8 мэдээлэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэлтэй холбоотой 12 мэдээлэл хугацаанд нь байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянцогт сумын Засаг даргын эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлэн, сумын Засаг даргын 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 01/187 дугаартай албан бичгээр хэрэгжилтийг ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	2	70,115.0	2	70,115.0	100
Нийт дүн	2	70,115.0	2	70,115.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянцогт сумын ОНХС-ийн иргэдийн санал авсан байдал, тендер шалгаруулалт, зарцуулалттай холбоотой асуудлыг авч үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 304,012.9 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 304,012.9 мянган төгрөгийн алдааг залруулав.

1. Засаг даргын нэгтгэсэн тайлангийн авлагын тодруулга тайланд 304,012.9 мянган төгрөгийн авлагын насжилтыг оруулаагүй, тооцоо нийлээгүй гэж тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн "ангилал", "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 63,021.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 63,021.8 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө 100,4 хувиар давж биелсэн боловч 6 нэр төрлийн орлого 10.3-98.9 хувиар буюу 63,021.8 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1-д "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.1-д "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр жигд биелүүлэх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагуудын санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1		1					
2	Засаг даргын тамгын газар	1	1			1			
3	Байгалийн нөхөн сэргээлтийн барьцаа сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Эмийн эргэлтийн сан	1		1					
6	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Засаг дарга	1	304,012.9			1	304,012.9	1	304,012.9				
ЗДТГ	2	58,757.74	1	51,105.34	1	7,652.40	2	58,757.74				
ХХС	1	364,000.0	1	364,000.0			1	364,000.0				
Дүн	4	726,770.6	2	415,105.3	2	311,665.3	4	726,770.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	63,021.8					1	63,021.8				
ИТХ	1	2,353.1	1	2,353.1								
ЗДТГ	3	9,243.5	1	9,243.5			2	-				
Дүн	5	74,618.4	2	11,596.6			3	63,021.8				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ОНХС	1	576,967.0					1	576,967.0
Дүн	1	576,967.0					1	576,967.0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	576,967.0					1	576,967.0